



## ТАТВАРЫН ТАЛААРХ ИЛЭН ДАЛАНГУЙ ЯРИА



### Албан татвар ба хөрөнгө: Элэгдэл тооцох тухай

Аливаа аж ахуйн нэгж, байгууллагад үйл ажиллагаагаа явуулахад хөрөнгө зайлшгүй шаардлагатай байдаг. Эдгээр хөрөнгийн зарим нь богино хугацаанд ашиглагддаг тул татварын тооцоо нь харьцангуй хялбар юм. Тухайлбал, бараа, материал, мөнгө зэрэг хөрөнгө үүнд хамаарна. Харин барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмж, компьютер зэрэг олон жил ашиглагдах, өндөр өртөг бүхий бист хөрөнгийн өртгийг хэрхэн татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцох вэ гэсэн асуулт гарч байна.

Дээрх асуултын хариу нь үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох явдал юм. Аж ахуйн нэгж, байгууллагууд үндсэн хөрөнгийг өртгөөр нь бүртгэх бөгөөд түүний өртгийг жил бүр зардалд хэсэгчлэн тусгадаг. Ийнхүү орлогыг гарсан зардалтай нь уялдуулснаар тухайн жилийн татвар ногдуулах орлогыг үнэн зөв тодорхойлох нөхцөл бүрдэнэ. Элэгдэл нь үндсэн хөрөнгийн өртгийг татварын олон тайлант үсүдэд хуваарилан тооцох цорын ганц арга юм.

Элэгдлийн тооцоог аль болох хялбарчлах зорилгоор татварын бүртгэлд үндсэн хөрөнгийг цөөн тооны бүлэгт хамааруулан үздэг. Харин санхүүгийн бүртгэлд аж ахуйн нэгж, байгууллагууд хөрөнгийн элэгдлийг ашиглах хугацаа буюу жилээр нь, эсвэл түүний хүчин чадалд тулгуурлан тооцдог тул үндсэн хөрөнгийн илүү олон төрөл шаардлагатай байдаг.

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүнд ихээхэн нөлөөлдөг тул татварын хуульд үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацааг тодорхойлсон заалт чухал байдаг. Үүнд үндсэн хөрөнгийн элэгдлийг хурдасгах (зарим гадаад орны татварын хуульд заасан) нь гол биш харин татварын зорилгоор тооцох хөрөнгийн ашиглагдах хугацаа нь тухайн хөрөнгийн бодит ашиглагдах хугацаанаас илүүгүй байх нь чухал юм. Үүний үр дүнд аж ахуйн нэгж, байгууллагууд үндсэн хөрөнгийн өртгийг бүрэн элэгдүүлэх боломжтой болох юм.

Хуулийн этгээдийн орлогын албан татварын хуулийн шинэчлэн найруулсан төсөл болон одоо мөрдөж буй хуульд заасан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг дараах хүснэгтээс үзнэ үү. Томоохон өөрчлөлт ороогүй боловч Монгол Улсын бизнесийн орчинд нийцүүлэн зарим өөрчлөлтийг тусгалаа.

Үндсэн хөрөнгийн бүлэг	Элэгдэл тооцох хугацаа (жилээр)	
	Одоо мөрдөж буй хууль	Өргөн барьсан хуулийн төсөл
Барилга, байгууламж	40	40
Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10	10
Компьютер, түүний эд анги, програм хангамж	5	5
Ашиглах хугацаа нь тодорхойгүй бист бус хөрөнгө	Заалт байхгүй	10
Ашиглах хугацаа нь тодорхой бист бус хөрөнгө (ашигт малтмалын лиценз г.м)	Заалт байхгүй	Эрх олгосон хугацаанд
Ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигчийн байгуулсан үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцэд зарцуулсан бүх хөрөнгө	Заалт байхгүй	Ашиглагдах хугацаанд
Бусад үндсэн хөрөнгө	10	10

Энэхүү мэдээлэл нь татварын шинэчлэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн арвангуравдугаар хэсэг юм. Та бүхэн уг цуврал болон өргөн барьсан хуулиудын төслийн электрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт ([www.open-government.mn](http://www.open-government.mn)), Сангийн яамны вэб сайт ([www.mof.pmis.gov.mn](http://www.mof.pmis.gov.mn)), УТЕГ-ын вэб сайт ([www.mta.mn](http://www.mta.mn))-аас үзэж, саналаа ирүүлж болно. Иргэдээс санал авах зорилгоор дээрх вэб сайтаас гадна олны танил болсон бусад вэб сайтуудад уг нийтлэлийг мөн гаргаж байгаа юм. Та бүхэн санал, сэтгэгдлээ үлдэнэ үү.